

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2021 оны 12 дугаар сарын 16

Сонгон шалгаруулалт шалгаруулалтын нэр: **Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших MV-011425 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн 7-р хүдрийн биетэд уулын ажил гүйцэтгэж бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

Монголросцветмет ТӨҮГ нь эрх бүхий оролцогчдоос бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **сүүлийн 2 жил буюу 2019 он, 2020 он.**

Жил тус бүрийн борлуулалтын орлого нь **500 сая төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **500 сая төгрөгөөс багагүй байх ба харилцагч банкнаас тодорхойлолт авах тохиолдолд уг сонгон шалгаруулалт ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий Захиалагчид гаргасан банкны тодорхойлолтыг шаардлага хангасан материал гэж үзнэ.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **сүүлийн 2 жил буюу 2019 он, 2020 он**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: **сүүлийн 2 жил буюу 2019 он, 2020 он**

Ижил төстэй ажил гэдэгт геологи хайгуулын болон уул уурхайн ашиглалт, хүдэр олборлолтын чиглэлээр ажиллаж байсан гэж ойлгох бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэж байсан туршлага бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **тийм, ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Геологи хайгуулын болон Уул уурхайн чиглэлээр олборлолтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий тэмдэглэлтэй байх**

Саналыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба сонгон шалгаруулалтыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 10 цаг 10 минутад нээнэ.

Гадаадын хуулийн этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхтэй

Улаанбаатар хот 51, ш/х – 002
Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,
“Монголросцветмет” ТӨҮГ-ийн байр, 504 тоот өрөө,
И-мэйл: mailbox@monros.mn.
Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-158,